

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 17 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 17 дугаар хуралдааныг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 15 цаг 15 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 81.8 хувийн ирцтэй хуралдав.

| Д/д | Хэлэлцсэн асуудал                                                                                                                                                                                                                                                        | Хурлаас гарсан шийдвэр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Монгол Улсын хөдөлмөрийн баатрууд болон Төрийн их баяр наадмын түрүү бөх, Монгол Улсын шинэ аварга О.Хангай, Монгол Улсын заан Б.Бат-Өлзий, Монгол Улсын начин Б.Сосорбарам, Монгол Улсын мэргэн Б.Мөнхзориг нарт хүндэтгэл үзүүлэх баяр наадмын төсөв хэлэлцүүлэх тухай | ШИЙДВЭРЛЭСЭН нь:<br>1. Монгол Улсын хөдөлмөрийн баатрууд, спортын алдартнуудад хүндэтгэл үзүүлэх баяр наадмын зардалд 82,0 сая төгрөгийг ард иргэд, аж ахуйн нэгж, компаниудаас хандив цуглуулах замаар бүрдүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал болон ажил хариуцсан албан тушаалтнуудад үүрэг болгов.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 2   | Бүх ард түмний 15 дугаар спортын их наадамд оролцох тамирчдын замын зардал хүссэн төсөв хэлэлцүүлэх тухай                                                                                                                                                                | ШИЙДВЭРЛЭСЭН нь:<br>1. Бүх ард түмний XV спортын их наадамд оролцох тамирчдын чансааг нь эрэмбэлж, төсвөө дахин хянаж танилцуулахыг Биеийн тамир спортын газрын хэлтсийн дарга Ч.Сүхбаатарт үүрэг болгов.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 3   | Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөтөлбөр дээр хүлээгдэж буй гүйцэтгэлийн асуудлыг хэлэлцүүлэх тухай                                                                                                                                                                   | ШИЙДВЭРЛЭСЭН нь:<br>1. Өмнөд америкийн Эквадор улсын Qirwa Anka хамтлагийн уран бүтээлчидтэй туршлага солилцох үйл ажиллагааны зардалд зарцуулагдах 9,435,100 төгрөг (есөн сая дөрвөн зуун гучин таван мянга нэг зуу)-ийг Байгаль орчин, аялал жуулчлал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын дэд хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас;<br>2. Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон Онцгой байдлын тэргүүн дэд бөгөөд штабын дарга, бригадын генерал Ж.Чүлтэмсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг Ховд сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан үйл ажиллагааны зардал 5,449,100 төгрөг (таван сая дөрвөн зуун дөчин есөн мянга нэг зуу)-ийг төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас тус тус санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд үүрэг болгов. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР